МЭДЭЭ · 2026 оны 3-р сарын 13

ЗӨРЧЛИЙН БҮРТГЭЛ МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ХЭВИЙН ЯВАГДАЖ БАЙНА



Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд "Зөрчил шалган шийдвэрлэх, хяналт тавих байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах, харилцан мэдээлэл солилцох зорилго бүхий зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сантай байна" гэж зааснаар нэгдсэн санг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн улсын хэмжээнд хэрэглээнд нэвтрүүлэн, үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Тус санд зөрчил шалган шийдвэрлэх 65 чиг үүргийн 953 байгууллагын 11,000 орчим эрх бүхий албан тушаалтны хүлээн авч шалгасан зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл, хэрэг бүртгэгдэж, зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд зааснаар зөрчил шалган шийдвэрлэхтэй холбоотой мэдээлэл нь хязгаарлалттай мэдээлэлд хамаардаг.

> Торгох шийтгэлийн төлбөр e-Mongolia төрийн үйлчилгээний нэгдсэн систем, "tpay.gov.mn" вэб хуудас болон арилжааны зарим банкаар дамжуулан Төрийн сангийн дансанд хэвийн төлөгдөж байна.

Одоогийн байдлаар зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтнууд болон шүүхээс 2026 онд оногдуулсан торгох шийтгэлийн 40 хувь нь биелэгдсэн байна.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/647